

1. Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх 8 сургагч багш ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтад хамрагдав

ЖАЙКА-ын Монгол дахь төлөөлөгчийн газар 3-р сарын 6-ны өдөр тус 8 сургагч багшийг хүлээн авч, сургагч багш бэлтгэх сургалтад амжилттай оролцсонд баяр хүргэж гэрчилгээг нь гардуулав. Мөн Монгол улсдаа хэрэгжүүлж болох ямар шинэ санал санаачлага олж харсан талаар харилцан сэтгэгдэлээ хуваалцлаа. Эдгээр сургагч багш нар Монгол улс дахь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд гол дэмжлэг үзүүлэх ажлын байрны дадлагажуулагчийг бэлтгэх юм.



Сургагч багш нар гэрчилгээгээ гардан авлаа.

Сургагч багш нар 3-р сарын 27-ноос 30-ны өдрүүдэд болох “Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх анхан шатны сургалт”-ын лекц, семинарын агуулга болон сургалтыг хэрхэн явуулах талаар харилцан ярилцаж, төлөвлөгөөгөө гаргаж байна. Тус сургалтаар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ААНБ болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжин ажиллах нийт 36 ажлын байрны дадлагажуулагчийг сургаж бэлтгэхээр төлөвлөж байна.

2. Ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагаатай танилцлаа



Ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагаатай танилцав

Ажлын байрны дадлагажуулагчийн ахлах зөвлөх, Профессор Огава Хироши багш 3-р сарын 14-өөс 16-ны өдрүүдэд Монголд ирж, ажлын байрны дадлагажуулагч 8 сургагч багш нарын үйл ажиллагаатай танилцаж, тэдэнд зөвлөгөө өглөө.

Манай сургагч багш нарын нэг Осоржалам 2022 оны 11-р сараас Чингэлтэй дүүрэгт байрлах солонгос хоолны ресторанд хөгжлийн бэрхшээлтэй нэгэн залууг ажилд оруулж, ажлын байранд нь дадлагажуулан ажиллаж байна.

Тухайн залууг ажилд орсон эхний өдөр нь аяга таваг угаах, хог хаях гэсэн зөвхөн хоёр төрлийн ажил дээр дадлагажуулжээ. Харин дараагийн шатанд аяга тавгаа хэрхэн угаах аргачлалыг ойлгомжтой байдлаар зааж өгчээ. Мөн угаалгын шингэний хэмжээг тааруулж хэрэглэхэд нь амар байхаар дарж гаргадаг сав байрлуулж өгснөөс дүрмийг нь бэлтгэж, байнга харагдах газар нь

гадна ажлын дараалал болон ажлын байранд баримтлах нааж өгөх зэргээр ажлын байрны тохируулгууд, орчны зохицуулалтыг хийжээ. “Ажлын бүтцэд өөрчлөлт хийх”, “Ойлгомжтой заах арга” буюу ажлын байрны дадлагажуулагч хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байранд нь дэмжлэг үзүүлэх үед ашигладаг үндсэн дүрмүүдийг ашиглажээ. Үүний үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй ажилтан ажлын байрандаа хурдан хугацаанд бие даан ажиллах чадвартай болсон байна.

Огава багш, Осоржаламыг ажлын байрны дадлагажуулагчийн баримтлах үндсэн дүрэм, аргачлалыг бодит байдал дээр сайн хэрэгжүүлсэн болохыг дурьдаад Монголд ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагаатай танилцсандаа ихэд баяртай байгаагаа хэлж байлаа. Осоржаламын хувьд, удахгүй болох “Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх анхан шатны сургалт”-д сургагч багшийн үүднээс илтгэл тавьж оролцох юм.



СЭДЭВ

1 Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх 8 сургагч багш ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтад хамрагдав.

2 Ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагаатай танилцлаа.

3 Вино үйлдвэрлэгч Комаки Вайнери үүссэн цагаасаа оюуны бэрхшээлтэй иргэдэд ажил олгож байна.

3. Монгол улсын хоёр оролцогч Японы ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжигч байгууллагуудтай танилцав - Вино үйлдвэрлэгч Комаки Вайнери үүссэн цагаасаа оюуны бэрхшээлтэй иргэдэд ажил олгож байна

Япон улсын Нагоя хот дахь ЖАЙКА-Чүбү төвөөс ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд сургалтад оролцогч зургаан орны төлөөлөл ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажилладаг Япон улсын томоохон корпораци болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч бизнесийн байгууллагуудаар зочилсон. Бид өмнөх мэдээгээрээ хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажиллуулдаг Тоёота Лүүпс компанийн үйл ажиллагааны тухай товч танилцуулсан билээ. Энэ удаад сэтгэц, оюуны бэрхшээлтэй хүмүүсийг ажиллуулдаг нэгэн жижиг үйлдвэрийг танилцуулахаар бэлтгэлээ.



Усан үзмийн талбайгаа танилцуулж байна.



Комаки вино үйлдвэрийн Даунтай ажилтан бие даан амьдардаг талаар танилцуулав.

Комаки хот дахь Эй Жэй Юү бие даан амьдрах төвийн халамжийн хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаа явуулдаг Комаки Вайнери гэх усан үзэм тариалж, дарс үйлдвэрлэн худалдаалдаг байгууллага. Биднийг очих үед усан үзэм тариалах улирал биш байсан ч Комаки Вайнери байгууллагын ажилтнууд усан үзмийн талбайгаа цэвэрлэх, засч янзлах гээд ажил ихтэй таарсан юм.

Ай Жэй Юү бие даан амьдрах төв 2003 оноос дарсны бизнес эрхэлж байгаад 2015 оноос усан үзэм тариалах, хураах, дарс хийж худалдаалах гэх мэт ажилд хөгжлийн бэрхшээлтэй тэр дундаа оюуны бэрхшээлтэй хүмүүсийн ажлын байрыг бий болгосон түүхтэй. Комаки Вайнери нь орон нутагтаа өөрийн гэсэн брэнд дарсны үйлдвэрийг байгуулахдаа эдгээр хүмүүст хөдөлмөр эрхэлж, ажилтай, орлоготой болж бие даан амьдрах боломжийг бий болгох зорилготой байсан ба одоо ч энэ зорилгынхоо төлөө үнэнчээр зүтгэн ажиллаж байгаа ажээ.

Түүнчлэн орон нутгийнхаа иргэд, байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг. Манай улсад ч хөгжлийн бэрхшээлгүй хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамтран орон нутгийнхаа брэнд бүтээгдэхүүн гарган ажиллах боломж нөөц их байгаа. Байгууллага тогтвортой үйл ажиллагаа явуулж, тогтвортой ашиг орлоготой байх үндэс нь олон нийтийн дэмжлэг, мөн тасралтгүй байх зарчим ажээ.



Комаки компаний гадаа 6 орны оролцогчид дурсгалын зураг татууллаа.

✉ dpub.jica@gmail.com

📍 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5

📘 <https://www.facebook.com/jicadpub1and2>

🌐 <https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>

